



ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 14 өдөр

Дугаар 9/240

Улиастай

“Үндэсний бахархал, Монгол өв соёл”
арга хэмжээг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Соёлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1 дэх заалтыг үндэслэн аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.6.1 дэх зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол үндэсний бахархал, эх оронч үзлийг төлөвшүүлж, соёлын өвийг хадгалж хамгаалах, өвлөн уламжлуулах “Үндэсний бахархал, Монгол өв соёл” арга хэмжээг нэгдүгээр, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.


2. Батлагдсан төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааны хэрэгжилтийг мэргэжил арга зүйн удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллаж, нэгтгэн тайлагнахыг Боловсрол, соёл урлагийн газар (Д.Бямбацогт), хэрэгжилтийг хариуцан ажиллахыг Соёл урлагийн байгууллагын дарга, сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусган санхүүжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ж.Хүрэлбаатар), Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Ж.Батцэнгэл)-т даалгасугай.

4. “Үндэсний бахархал, Монгол өв соёл” арга хэмжээний хэрэгжилтийг хагас жил тутамд тайлагнахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (А.Шаравжамц), хэрэгжилт, тайланд жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж үр дүнг танилцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс (Н.Бямбадорж)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ТҮВШИНЖАРГАЛ



E/zakhiramj2021

811210711

Аймгийн Засаг даргын 2021 оны 06
дугаар сарын 17-ны өдрийн
~~А/Д~~ дугаар захирамжийн
нэгдүгээр хавсралт

“ҮНДЭСНИЙ БАХАРХАЛ, МОНГОЛ ӨВ СОЁЛ” АРГА ХЭМЖЭЭ
8119285296 9039287
НЭГ. ҮНДЭСЛЭЛ, ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод “Үндэсний бахархал, эв нэгдэл”-ийн талаар “Төрт ёсны уламжлал, түүх, соёлын дурсгал, утга зохиол, урлагийн бүтээлээр үндэсний бахархал төлөвшүүлж, эх оронч үзэл, эв нэгдлийг нягтруулна” гэсэн зорилт,

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д Нүүдлийн өв соёлоо хадгалж, ёс заншил, уламжлалаа түгээн дэлгэрүүлнэ, өв соёл, зан заншлаа дээдэлсэн, бүтээлч, оюунлаг, үндэсний соёлын мэдлэг, чадвар, дадалтай монгол хүнийг төлөвшүүлж, монгол өв соёлыг түгээн дэлгэрүүлэх,

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т Үндэсний бахархал, өв соёлын талаар “Үндэсний үнэт зүйл, уламжлалт өв соёлоо дээдэлж, иргэдийг соён гэгээрүүлж, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэн, дэлхийн нүүдлийн соёл иргэншлийн төв болно” гэсэн зорилт дэвшүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын 2012 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс соёлын талаар баримтлах бодлого”-д “Соёлын үнэт зүйлийг иргэд бүтээн бий болгох, хүртэх, эзэмших, уламжлах, соёлын өвийг найдвартай хадгалах, хамгаалах орчин нөхцөлийг бүрдүүлэх, уламжлалт соёлоо дэлхий нийтэд сурталчлан таниулах, үндэсний хөгжилд соёлын эзлэх байр суурь, оруулах хувь нэмэр, үр ашгийг дээшлүүлэх, соёлын үйл ажиллагаанд иргэн, гэр бүл, байгууллагын оролцоог нэмэгдүүлж, монгол хүнийг бага наснаас нь хүмүүнлэг, оюунлаг, соёл уламжлалаа дээдэлдэг иргэн болгон төлөвшүүлэх” -ийг эрхэм зорилго болгосон.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 13 дугаар тогтоолоор батлагдсан “Завхан аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д Өв соёлын талаар “Эх хэл, түүх, өв соёлоо дээдэлсэн эх оронч үзэл, эв нэгдлийг эрхэмлэсэн монгол хүнийг хөгжүүлнэ” гэсэн зорилго,

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 14 дүгээр тогтоолоор батлагдсан “Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т “үндэсний үнэт зүйл, уламжлалт өв соёлоо дээдэлж, иргэдийг соён гэгээрүүлэн соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлнэ, мэргэжлийн урлагийн байгууллага, соёлын төвүүдийг шаардлагатай хөгжмийн зэмсэг, хувцас хэрэглэлээр хангана, “Цахим соёл”, “Бүх нийтийн соёлын боловсрол” арга хэмжээг хэрэгжүүлэх, соёл урлагийн салбарыг

мэргэжлийн боловсон хүчнээр бүрэн хангаж, мэргэшүүлэх ажлыг шат дараатай зохион байгуулна гэсэн зорилт,

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Аймгийн 2021 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө”-нд Үндэсний нэгдмэл баходхлыг сэргээж, эх хэл, түүх, өв соёлоо дээдэлсэн эх оронч үзэл, эв нэгдлийг эрхэмлэсэн Монгол хүнийг хөгжүүлж, нийгмийг соён гэгээрүүлнэ гэсэн зорилтыг тус тус дэвшүүлсэн байна.

Аймгийн соёл, урлагийн салбарын өнөөгийн байдал

Соёл урлагийн 26 байгууллагад 212 ажилтан ажиллаж байна. Ажиллагсдын 76.5% нь мэргэжлийн, 18.5 хувь нь мэргэжлийн бус, 5% нь мэргэжил эзэмшихээр суралцаж байна. Нийт ажиллагсдын 44.4% эрэгтэй, 55.6% нь эмэгтэй бөгөөд 25-45 наасныхан 65%, 45-аас дээш наасныхан 35%-ийг эзэлж байна.

Бүрэн дунд боловсролтой 64, дипломын болон баклаврын боловсролтой 130, магистр 17, докторант 1 ажиллаж байна. Соёл, урлагийн салбарт ажиллаж байгаа ажилтнуудын 80 хувь нь төр засгийн шагнал хүртсэн бөгөөд Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонт 2, Алтан гадас одонт 2, Монгол Улсын соёлын тэргүүний ажилтан 58 байна.

Соёл, урлагийн салбарт Хэлний бодлогын Үндэсний зөвлөлийн салбар зөвлөл, бүжгийн сургалтын төвүүд, уран зургийн дугуйлан, Монголын урчуудын эвлэлийн салбар, утга зохиолын нэгдэл, залуу зохиолчдын холбоо, угийн бичгийн академийн салбар, монголын Ураг уدام уламжлалын холбооны салбар, “Алтан өргөө” төрийн бус байгууллага (хүүхэлдэйн театр), нийтийн бүжгийн холбоо зэрэг байгууллагууд ажиллаж байна.

2016-2020 онд “Боловсрол, соёл урлагийн салбарыг хөгжүүлэх” дэд хөтөлбөрийг соёл урлагийн салбарт 5 зорилт, 21 арга хэмжээг хэрэгжүүлсэний үр дүнд:

Фургон автомашины шагналтай “Манлай соёлын төв” шалгаруулах уралдаан, уламжлалт “Очирваанийн Их эгшиглэн”, “Бадархундага” яруу найргийн наадам, “2000” уран сайхны кино, “Өндөр гэгээн” дуулалт жүжиг, 3030 морин хуурчдын нэгдсэн тогтолт, Түүх соёлын хөдлөх дурсгалын улсын тооллого, “Хаврын баяр” урлаг спортын наадам, “Соёлын биет бус өвийн бүтээл”-ийн уралдаан зэрэг үйл ажиллагааг зохион байгуулан, соёлын байгууллагын 40 хувь нь шинэ барилгатай болж, тайз гэрэлтүүлэг, техник аппаратур, хөгжмийн зэмсэг, тоног төхөөрөмжийг шат дараатайгаар шинэчилсэн байна.

Эх оронч үзэл

“Бид Чингисийн үр сад, зөв тэмүүлэл, эх оронч манлайлал” арга хэмжээг 2018 онд зохион байгуулж, 24 сумын Ерөнхий боловсролын 29 сургуулийн ахлах ангийн 1279 суралцагч, сургуулийн захирал, анги удирдсан багш, нийгмийн ажилтан, Хууль сахиулахын их сургуулийн сонсогч, багш нар нийт 1393 хүн оролцсон байна.

Соёлын биет өв

Завхан аймгийн нутагт хадгалагдан үлдсэн түүх, соёлын үл хөдлөх дурсгалаас

1. Алдархаан сумын Богдын голын “Мөнгөт хясаа”-нд байрлах 4 хүний зураг бүхий чулуун хөшөө
2. Баянтэс сумын Хөх хошууны боомын булшнууд
3. Цэцэн-Уул сумын “Янжывын шил”-д байрлах хүн чулуун хөшөөнүүд
4. Шилүүстэй сумын “Дааган дэл”-д байрлах 8 ширхэг буган чулуун хөшөө
5. Яруу сумын Ярууний голын эрэгт орших хүн чулуун хөшөө нь Засгийн газрын “Жагсаалт батлах тухай” 2020 оны 13 дугаар тогтоолоор улсын хамгаалалтанд байдаг.

2015 онд хийгдсэн “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын улсын үзлэг, тооллого”-оор аймгийн нутаг дэвсгэрт 729 дурсгалт газрын 8934 дурсгал бүртгэгдсэн ба үүнээс аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 07 дугаар тогтоолоор 312 цэгийн 1212 үл хөдлөх дурсгалыг орон нутгийн хамгаалалтанд авсан байна.

Эдүгээ аймгийн нутаг дэвсгэрт буган чулуун хөшөө 171, барилга архитектурын дурсгал 34, тахил тайлгын байгууламж 647, булш оршуулгын дурсгал 7100, хадны зураг, бичгийн дурсгал 102, хөшөө дурсгал 773 байна.

Соёлын биет бус өв

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 475 дугаар тогтоолоор Монгол Улсын гавьяат жүжигчин Лувсандоржийн Жавзан ардын богино дуугаар, Монгол Улсын ардын жүжигчин Бэгзсүрэнгийн Норовсамбуу уран нугаралтаар, Монгол Улсын Урлагийн гавьяат зүтгэлтэн хөөмийч Баатарын Одсүрэн хөөмийгөөр, Монгол Улсын Соёлын тэргүүний ажилтан Цэрэнбалжирын Цэвэгсүрэн Лимбэний битүү амьсгаагаар, Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн Зандраагийн Түмэн-Өлзий монгол оньсон тоглоом наадгайгаар соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийн Үндэсний жагсаалтад бүртгэлтэй байдаг. Аймгийн хэмжээнд 2020 оны байдлаар 550 соёлын биет бус өвийн өвлөн уламжлагч бүртгэлтэй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 354 дүгээр тогтоолын хүрээнд соёлын биет бус өвийн шилдэг өвлөн уламжлагчийн мөнгөн шагналд 2019, 2020 онд Их-Уул сумын иргэн Батбаярын Тунгалаг Монгол гутлыг зүү ороох уламжлалт оёдлоор, 2020 онд ахмад уран бүтээлч, уртын дуучин Соёлын тэргүүний ажилтан Б. Гэрэлтогтох уртын дуугаар нэр дэвшиж оролцсон байна.

Соёлын өвийн хадгалалт, хамгаалалт

Яруу сумын Өргөний арын хүн чулуун хөшөө дурсгал, Шилүүстэй сумын Дааган дэлийн буган чулуун хөшөө, Идэр сумын Ар дугуйтын буган чулуун хөшөөнд хайс хамгаалалт хийж, орон нутгийн хамгаалалтанд авсан **ба** Дөрвөлжин сумын “Баян-Айраг”-ийн уурхайн тэсэлгээнд өртөж хагарсан хадны зураг, Нөмрөг сумын Өвөр шивэртэйн голд унасан буган чулуун хөшөөг авран хамгаалж, сэргээн засварлах шаардлагатай байна.

Соёлын биет бус нь эзэн хүнтэйгээ устаж үгүй болох онцлогтой тул өвлөн уламжлагчдыг нээн илрүүлэх, бүртгэн баримтжуулах, хадгалах хамгаалах, өвлөн уламжлуулах ажлыг эрчимжүүлэх хэрэгтэй байна.

Угийн бичиг

Угийн бичгийн чиглэлээр хэлэлцүүлэг, зөвлөгөөн, арга зүйн шат дараалан сургалтыг 18 удаа зохион байгуулж, 130 сургагч багшийг бэлтгэн, 15000 иргэнд

мэдээллийг хүргэж ажилласан ба аймгийн хэмжээнд угийн бичиг хөтөлдөг өрхийн тоо 2020 оны байдлаар 5500 байна.

Монгол бичиг

Хэлний бодлогын Үндэсний зөвлөлийн орон тооны бус салбар зөвлөл нь Монгол хэлний тухай хууль, “Монгол бичгийн Үндэсний хөтөлбөр III”-ийн хэрэгжилтийг ханган ажиллаж, “Миний монгол 2025” төслийн хүрээнд бийрэн бичлэгийн сургалтанд 1800 суралцагч, 130 багш суралцаж, ур чадвараа сайжруулсан ба “Хос бичигтэн” цахим аянд аймгийн ЕБС-ийн 495 багийн 1833 суралцагч, багш, эцэг эх оролцсон байна.

Соёл урлагийн салбарын өнөөгийн байдалд хийсэн “SWOT” шинжилгээ

Давуу тал	Сул тал
<ul style="list-style-type: none"> - “БСУ-ийн салбарыг хөгжүүлэх” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж, тодорхой үр дүн гарсан; - Соёлын яам шинээр байгуулагдсан; - Хөгжимт жүжгийн театрыг түшиглэн томоохон уран бүтээл туурвих боломжтой; - СУИС-ийн салбар ХБК-ийг түшиглэн соёлын байгууллагуудыг мэргэжлийн боловсон хүчинээр хангах боломжтой; - Соёлын байгууллагын 40 гаруй хувь нь шинэ барилгатай болсон; - Аймгийн түүх соёлын үл хөдлөх дурсгалыг орон нутгийн хамгаалалтад авсан; - Түүхэн кино, жүжиг, томоохон нэгдсэн тоглолтыг зохион байгуулсан туршлага; - Соёлын байгууллагууд өөрийн орлогоо захиран зарцуулах эрхтэй болсон. 	<ul style="list-style-type: none"> - Соёлын байгууллагуудад компьютер, тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл, ардын хөгжмийн зэмсэг, тогтолтын хувцас, хэрэглэл дутагдалтай; - Батлагдсан төсөв, санхүүжилт бага - Олон улсын болон гадаадын тесэл хөтөлбөрт хамрагдах боломж бага - Ажилтнууд хөдөө орон нутагт тогтворт суурьшилтай ажилласны нэмэгдэл авдаггүй; - Уран бүтээлчдийн тогтворт суурьшил муу - Сум, орон нутагт мэргэжилтэй боловсон хүчний нөөц хязгаарлагдмал - Түүх соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалахад иргэн, хуулийн этгээдийн оролцоо сул - Угийн бичиг хөтөлдөг өрхийн тоо бага
Боломж	Эрсдэл
<ul style="list-style-type: none"> -Аймаг, орон нутгийн дэмжлэг сайн -Цахим орчинд ажиллах боломжтой -Төрийн бус байгууллага, сургалтын төвүүдийн хамтын ажиллагаа 	<ul style="list-style-type: none"> -“Ковид 19” цар тахал -Соёлын биет өвийн хууль бус малтлага -Уул уурхайн үйл ажиллагаа -Соёлын биет бус өвийн өвлөн уламжлагчдын насжилт богино

“Үндэсний бахархал, монгол өв соёл” арга хэмжээг хэрэгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөөг соёл урлагийн салбарын 2020 оны статистик мэдээнд дүн шинжилгээ хийж, соёл урлагийн байгууллагын 180 ажилтан, 26 удирдах ажилтан, төрийн бус

байгууллагын төлөөлөл 300 гаруй хүний саналыг тусган боловсруулсан ба төслийг цахимаар ажлын хэсэг, удирдах ажилтан, албан хаагчид, иргэд олон нийтэд хэлэлцүүлэн сайжрууллаа.

ХОЁР. ЗОРИЛГО

Монгол үндэсний бахархал, эх оронч үзлийг төлөвшүүлж, соёлын өвийг хадгалж хамгаалах, өвлөн уламжлуулахад оршино.

ГУРАВ. ЗОРИЛТ

- 3.1. Үндэсний бахархал, эх оронч үзлийг төлөвшүүлэхэд бүх талын оролцоог хангах;
- 3.2. Соёлын биет болон биет бус өвийг судлах, сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлэх, өвлөн уламжлуулах, хадгалах хамгаалах;
- 3.3. Угийн бичиг хөтөлдөг айл өрхийн тоог нэмэгдүүлэх;
- 3.4. Үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх, хэрэглээний орчин бүрдүүлэх;
- 3.5. Соёл урлагийн байгууллагын хүний нөөцийг чадавхжуулж, орчин нөхцөлийг сайжруулах

ДӨРӨВ. ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА

- 4.1. 2021-2024 онд хэрэгжүүлнэ.

ТАВ. САНХҮҮЖИЛТ

- 5.1. “Үндэсний бахархал, монгол өв соёл” арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:
 - 5.1.1. улсын болон орон нутгийн төсөв;
 - 5.1.2. байгууллагын өөрийн хөрөнгө, орлого;
 - 5.1.3. иргэн, аж ахуйн нэгжийн хандив;
 - 5.1.4. олон улсын болон гадаад улсын зээл, тусlamж;
 - 5.1.5. хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэр.

Нийт төсөв-1969.2

Үүнээс: ОНТ – 477.2
БӨХ – 1210.0
ТХ- 282.0

ЗУРГАА. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ ТҮВШИН

д/д	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин			
				2021	2022	2023	2024
1	Эх оронч үзэл төлөвшүүлэх олон талт үйл ажиллагаанд оролцогчид	Too	3200	7900	11420	17130	26600
2	Хадгалалт,	Too	2	4	6	8	10

	хамгаалалтыг сайжруулсан түүх соёлын үл хөдлөх дурсгал						
3	Соёлын биет бус өвийг сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлэх олон талт арга хэмжээнд оролцогчдын хүн амд эзлэх хувь	Хувь	40	50	65	85	100
4	Шинээр нээн илрүүлж, бүртгэн баримтжуулсан Соёлын биет бус өвийн өвлөн уламжлагчид	Тоо	550	555	558	560	562
5	Биет бус өвийг сурталчлах, хамгаалахад зориулж бэлтгэсэн контент	Тоо	1	5	10	15	20
6	Номын сангийн фондонд цахим сангийн эзлэх хувь	Хувь	0	0	1	2	3
7	Угийн бичиг хөтөлдөг өрх	Тоо	5500	8000	12000	15000	17000
9	Монгол бичгийн мэдлэгээ ахиулсан 18 наснаас дээш иргэдийн эзлэх хувь	Хувь	40	50	60	80	90
10	Монгол бичгийн мэдлэгээ ахиулсан төрийн албан хаагчдын эзлэх хувь	Хувь	40	50	60	80	90
11	Мэргэжилтэй боловсон хүчний эзлэх хувь	Хувь	65	76	87	95	100
11	Шинээр баригдсан барилга	Тоо	6	7	11	17	18
12	Засвар хийгдсэн барилга	Тоо	4	4	5	7	8

ДОЛОО. ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭ

7.1. Аймгийн Боловсрол, соёл урлагийн газар нь мэргэжил арга зүйн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллана.

7.2. Соёл, урлагийн байгууллагууд хэрэгжилтийг хариуцан ажиллаж, жил бүрийн 6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-ний өдрийн дотор Боловсрол, соёл урлагийн газарт цаасаар болон цахимаар тайлagnана.

7.3. "Үндэсний бахархал, монгол өв соёл" арга хэмжээний хэрэгжилтэд аймгийн Засаг даргын тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс хэрэгжилт, тайланд жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, мөн Иргэний нийгмийн байгууллагын зүгээс төрийн байгууллагатай хамтран үнэлгээ хийнэ.

7.4 Хэрэгжилтийн явцын үнэлгээг үндэслэн өөрчлөлт оруулж болно.

НАЙМ. ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧИГ

1. Монгол Улсын Соёлын тухай хууль
2. Монгол Улсын Соёлын өвийг хамгаалах тухай хууль
3. "Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал" Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоол
4. "Монголын Нууц Товчоог мөнхөд эрхэмлэн дээдлэх тухай" Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2004 оны 23 дугаар зарлиг
5. "Уртын дуугаа өвлөн дэлгэрүүлэх тухай" Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2004 оны 134 дүгээр зарлиг
6. "Эх хэлний өдөр зарлах тухай" Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны 25 дугаар зарлиг
7. "Алсын хараа-2050" Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоол
8. "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл" Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоол
9. "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр" Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоол
10. "Төрөөс соёлын талаар баримтлах бодлого" Монгол Улсын Их Хурлын 2012 оны 52 дугаар тогтоол
11. "Завхан аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл" Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 13 дугаар тогтоол
12. "Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр" Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 14 дүгээр тогтоол

-----000-----

Аймгийн Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 17-ны
өдрийн 140 дугаар замжрамжийн хөөрдугаар хавсралт

"ҮНДСНИЙ БАХАРХАЛ, МОНГОЛ ӨВ СОЁЛ" АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Шалгуур узүүлэлт	Суурь түшиг	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая тег)	Хурах түвшин, үр дүн, төсөв								Хэрэгжүүлэх байгууллага		
						2021 он		2022 он		2023 он		2024 он		Үндсэн	Хамтрагч	Оролцогч
						Хурах түвшин	Төсөв (сая тег)	Хурах түвшин	Төсөв (сая тег)	Хурах түвшин	Төсөв (сая тег)	Хурах түвшин	Төсөв (сая тег)			
Нэг. Үндсний баҳархал, эх оронч үзлийг төлөвшүүлэхэд бүх талын оролцогч хангах, томоохон хэмжээний уран бүтээл туурвиж борилтын хүрээнд:																
1	Нийгмийн нэрг зүтгэлтийнуд, цэрэг дайчдын амьдрал ахуйг харуулсан түүхэн үйл явдлыг таниулах сургалчны ажлыг зохион байгуулна.	Хэрэгжилтийн хувиар	30%	ОНТ БӨХ ТХ Нийт	15.0 20.0 5.0 40.0	50%	10.0	70%	10.0	80%	10.0	100%	10.0	Цэргийн штаб БСУГ, ГБХЭХГ	9039287	ЕБС
2	Эх орны узэсгэлэнт байгаль, түүхэн газар орноор сонсогч икютэн сургалчыг тайрон авалуулах хедалтгэн өрнүүлнэ.	Оролцогчдын тоо	18	ОНТ БӨХ ТХ Нийт	5.0 7.5 5.0 17.5	20	2.0	30	2.5	60	5.0	90	8.0	Цэргийн штаб БСУГ, ГБХЭХГ		ЕБС
3	"Дөл" тэмцээний ЕБС-ийн алхах ангийн сургалчын дунд эхийн байгуулна.	Оролцогчдын тоо	240	ОНТ БӨХ ТХ Нийт	8.0 20.0 8.0 36.0	300	9.0	360	9.0	400	6.0	480	12.0	Цэргийн штаб ГБХЭХГ, БСУГ, 3Х-р анги, ОБГ		ЕБС
4	Үндсний баҳархал, эх оронч үзлийг төлөвшүүлэх видео контент балгана.	Контентын тоо	0	ОНТ БӨХ ТХ Нийт	5.0 25.0 5.0 35.0	10	10.0	20	10.0	25	5.0	35	10.0	Соёл урлагийн байгууллага БСУГ, ГБХЭХГ		Бүх шатны сургалтын байгууллага
5	Монгол зан заншил, өв соёлыг сурталчлан таниулах сургалтын танихим байгуулахад дэмжлэг үзүүлнэ.	Танхимын тоо	30	ОНТ БӨХ ТХ Нийт	90.0 360.0 62.0 512.0	35	40.0	50	120.0	75	200.0	94	152.0	Боловсрол, соёлын байгууллага БСУГ, ГБХЭХГ		Аймаг, сумын ЗДТГ, ТББ
6	Үндсний баҳархал, өв соёлыг харуулсан томоохон уран бүтээл туурвила.	Уран бүтээлийн тоо	2	ОНТ БӨХ ТХ Нийт	10.0 60.0 10.0 80.0	3	20.0	4	20.0	5	20.0	6	20.0	Хөгжимт жүжийн театр БСУГ		АЗДТГ
7	Сургалчадад зориулсан эх оронч үзэл төлөвшүүлэх олон талт нөхөнэллийн ажлыг нэмргүүлнэ.	Оролцогчдын тоо	8000	ОНТ БӨХ ТХ Нийт	7.0 35.0 10.0 52.0	10000	10.0	15000	20.0	18000	12.0	20000	10.0	Бүх шатны сургалтын байгууллага БСУГ, ГБХЭХГ		Соёл урлагийн байгууллага
Хоёр. Соёлын биет болон биет бус өвийг судлах, сургалчлан таниулах, түгээн дэлгэрүүлэх, өвлөн уламжлуулах, хадгалах хамгаалах зорилтын хүрээнд:																
8	Эрдэнэхайрхан сумын Хар нуур орчмын буган чулуун хөшөө, Идэр сумын буган чулуун хөшөөг хашиж хамгаалана.	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	0	БХСАХЗ Нийт	10.0 10.0	2	10.0								БОАЖГ, БСУГ АЗДТГ	Музей, Соёлын төв
9	Соёлын биет болок биет бус өвийн судалгаа мэдээллийн нэгдсэн санд холбогдоно.	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	0	ОНТ БӨХ ТХ Нийт	10.0 50.0 10.0 70.0	30%	25.0	50%	15.0	70%	15.0	100%	15.0	Соёл урлагийн байгууллага БСУГ		СЯ, СӨҮТ
10	Соёлын биет бус өвийг сургалчлан таниулах, түгээн дэлгэрүүлэх олон талт арга хэмжээг зохион байгуулна.	Оролцогчдын хувь	40%	ОНТ БӨХ ТХ Нийт	20.0 70.0 10.0 100.0	50%	20.0	65%	30.0	80%	25.0	100%	25.0	Соёл урлагийн байгууллага БСУГ, СЗДТГ		Төрийн болон төрийн бус байгууллага

			Чөвлөн уламжлагчдын тоо	550	БВХ ТХ Нийт	18.0 10.0 30.0	555	10.0	558	8.0	560	6.0	562	6.0	БСУГ, Музей	аймаг, сумын ЗДТГ	Соёл урлагийн байгууллагууд	
11	Соёлын биет бус евийн өвлиен уламжлагчдын нээн иргүүлж, бүртгэн баримтуулна.				ОНТ БВХ ТХ Нийт	5.0 20.0 15.0 40.0	10	10.0	15	10.0	22	12.0	26	8.0	Музей	БСУГ	СВҮТ, Соёлын төв	
12	Түх сүйлийн ул хөдлөх дурсгал, хөшөө баримтуудын зурагт альбом, ном тохижмол гаргаж ард иргээд сурталчлан таниулна.	ном тохижмолын тоо	5		ОНТ БВХ ТХ Нийт	10.0 55.0 10.0 75.0	0		1	35.0			1	40.0	БСУГ	АЗДТГ	СВҮТ, Соёлын төв	
13	Соёлын биет бус евийн өвлиен уламжлагчдын анхдугаар их наадмыг зохион байгуулна.	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	0		ОНТ БВХ ТХ Нийт	10.0 55.0 10.0 75.0												
14	Аймгийн Засаг дарын нарэмжит "Өсвөрийн морин хуурч" уралдааны зохион байгуулна.	Оролцогчдын тоо	300		ОНТ БВХ ТХ Нийт	23.0 40.0 15.0 63.0	500	10.0	650	15.0	700	18.0	800	20.0	БСУГ	АЗДТГ, СИИС-ийн салбар ХБК	ЕБС	
15	Номын сангийн цахим сан, фондыг баягуулна.	Цахим сангийн эзлэх хувь	0		ОНТ БВХ ТХ Нийт	14.0 90.0 40.0 144.0	0		1%	48.0	2%	48.0	3%	48.0	Төв номын сан	БСУГ, Үндэсний номын сан	СЯ, Соёлын төв	
16	Биет бус евийг сурталчлах, хамгаалахад зориулж видео контент бэлтгэнэ.	Контентын тоо	1		ОНТ БВХ ТХ Нийт	5.0 13.0 2.0 20.0	5	5.0	10	5.0	15	5.0	20	5.0	БСУГ, Оройн чимэг НҮТББ	АЗДТГ	Төрийн болон төрийн бус байгууллага	
17	Түүхэн дурсгалт газруудын мэдээллийн сан бий болгоно.	Мэдээллийн тоо	22		ОНТ БВХ ТХ Нийт	8.0 7.0 15.0	150	2.0	400	3.0	750	4.0	1212	6.0	Музей	БСУГ	Соёлын төв	
18	Музейн хосгүй ховор, үнэт дурсгал, үзмэр, эд өлгийн зүйлийг бүртгэлжүүлж дурсгалд хамруулна.	Даатганд хамрагдсан дурсгалын тоо	0		ОНТ БВХ ТХ Нийт	5.0 15.0 20.0	1	2.0	3	4.0	6	6.0	10	8.0	Музей	БСУГ	МХГ, СВҮТ, Соёлын төв,	
19	Ховор эд өлгийн зүйлс эзэмшигчэд гарчилгээ олгож урамшуулна.	Гэрчилгээ олгосон иргэдийн тоо	0		ОНТ Нийт	3.2 3.2	1	0.8	2	0.8	3	0.8	4	0.8	Музей	БСУГ	СВҮТ, Соёлын төв,	
20	"Отгонтэнгэр хайрхан" баримтат кино бүтээхэд дэмжлэг үзүүлнэ.	Хэрэгжилтийн хувь	0		ОНТ Нийт	50.0 50.0	1	50.0								АЗДТГ	БСУГ	Төрийн болон төрийн бус байгууллага
21	"Бадархуудага" яруу найгийн наадам зохион байгуулна.	Оролцогчдын тоо	120		ОНТ БВХ ТХ Нийт	8.0 6.0 4.0 18.0			150	8.0			200	10.0	АЗДТГ, УЗН	БСУГ	Төрийн болон төрийн бус байгууллага	
22	"Очирааванийн их эгшиглэн" яруу найгийн наадам зохион байгуулна.	Оролцогчдын тоо	150		ОНТ Нийт	50.0 50.0							200	50.0	АЗДТГ	БСУГ	УЗН, Соёл урлагийн байгууллага	
23	"Хөвр их хутагт II" олон улсын эрдэм шинжилгээний хурал зохион байгуулна.	Оролцогчдын тоо	50		ОНТ ТХ Нийт	10.0 20.0 30.0							100	30.0	АЗДТГ	БСУГ, Музей	Төгс бүйнт хавхийн хийд	
24	"Засагт хан аймгийн тамгын хайрца"-ны загвараар сөйлийн үйлдвэрлэл бий болгоно.	Бүтээгдэхүүний тоо	0		ОНТ БВХ ТХ Нийт	7.0 3.0 40.0 10.0	50	10.0								АЗДТГ	БСУГ, Музей	Төрийн болон төрийн бус байгууллага
Гурав. "Угийн бичиг хөтөлдөг айл өрхийн тоог нэмэгдүүлэх" зорилтын хүрээнд:																		
25	Угийн бичиг хөтөлж арга зүйн сургалтыг зохион байгуулна.	Оролцогчдын тоо	1500		ОНТ БВХ ТХ Нийт	5.0 30.0 5.0 40.0	3000	8.0	5000	10.0	8500	10.0	12000	12.0	ГБХЗХГ, БСУГ, ЭМГ	АЗДТГ	Төрийн болон төрийн бус байгууллага	
26	Угийн бичгийн талаар видео контент,	Контентын тоо	n		ОНТ БВХ	3.0 24.0	5	5.0	10	5.0	20	10.0	20	10.0	ГБХЗХГ, БСУГ,	Музей,	Төрийн болон төрийн бус байгууллага	

	хамгаалалтыг сайжруулсан түүх соёлын үл хөдлөх дурсгал						
3	Соёлын биет бус өвийг сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлэх олон талт арга хэмжээнд оролцогчдын хүн амд эзлэх хувь	Хувь	40	50	65	85	100
4	Шинээр нээн илрүүлж, бүртгэн баримтжуулсан Соёлын биет бус өвийн өвлөн уламжлагчид	Тоо	550	555	558	560	562
5	Биет бус өвийг сурталчлах, хамгаалахад зориулж бэлтгэсэн контент	Тоо	1	5	10	15	20
6	Номын сангийн фондонд цахим сангийн эзлэх хувь	Хувь	0	0	1	2	3
7	Угийн бичиг хөтөлдөг өрх	Тоо	5500	8000	12000	15000	17000
9	Монгол бичгийн мэдлэгээ ахиулсан 18 наснаас дээш иргэдийн эзлэх хувь	Хувь	40	50	60	80	90
10	Монгол бичгийн мэдлэгээ ахиулсан төрийн албан хаагчдын эзлэх хувь	Хувь	40	50	60	80	90
11	Мэргэжилтэй боловсон хүчний эзлэх хувь	Хувь	65	76	87	95	100
11	Шинээр баригдсан барилга	Тоо	6	7	11	17	18
12	Засвар хийгдсэн барилга	Тоо	4	4	5	7	8

ДОЛОО. ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭ

7.1. Аймгийн Боловсрол, соёл урлагийн газар нь мэргэжил арга зүйн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллана.

7.2. Соёл, урлагийн байгууллагууд хэрэгжилтийг хариуцан ажиллаж, жил бүрийн 6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-ний өдрийн дотор Боловсрол, соёл урлагийн газарт цаасаар болон цахимаар тайлagnана.

7.3. "Үндэсний бахархал, монгол өв соёл" арга хэмжээний хэрэгжилтэд аймгийн Засаг даргын тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс хэрэгжилт, тайланд жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, мөн Иргэний нийгмийн байгууллагын зүгээс төрийн байгууллагатай хамтран үнэлгээ хийнэ.

7.4 Хэрэгжилтийн явцын үнэлгээг үндэслэн өөрчлөлт оруулж болно.

НАЙМ. ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧИГ

1. Монгол Улсын Соёлын тухай хууль
2. Монгол Улсын Соёлын өвийг хамгаалах тухай хууль
3. "Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал" Монгол Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоол
4. "Монголын Нууц Товчоог мөнхөд эрхэмлэн дээдлэх тухай" Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2004 оны 23 дугаар зарлиг
5. "Уртын дуугаа өвлөн дэлгэрүүлэх тухай" Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2004 оны 134 дүгээр зарлиг
6. "Эх хэлний өдөр зарлах тухай" Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны 25 дугаар зарлиг
7. "Алсын хараа-2050" Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоол
8. "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл" Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоол
9. "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр" Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоол
10. "Төрөөс соёлын талаар баримтлах бодлого" Монгол Улсын Их Хурлын 2012 оны 52 дугаар тогтоол
11. "Завхан аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл" Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 13 дугаар тогтоол
12. "Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр" Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 14 дүгээр тогтоол

-----000-----